



2026 оны намрын улирал
Шинхан Их Сургуулийн магистр,
доктор гадаад оюутны элсэлтийн журам
(шинээр болон шилжин суралцах)

Гарчиг

0.	Элсэгчдэд тавигдах нийтлэг шаардлага	2P
1.	Элсэлтийн хуваарь	3P
2.	Элсэгч авах нэгж болон бҮртгҮҮлэгчийн шалгуур	4P
3.	Шалгаруулалтын аргачлал	7P
4.	Бичиг баримт бҮрдҮҮлэх заавар	8P
5.	Онлайн элсэлтийн бҮртгэлийн аргачлал болон шалгаруулалтын хураамжийн дэлгэрэнгүй мэдээлэл	13P
6.	Тэтгэлэг олгох тогтолцоо	15P
7.	Сургалтын төлбөр төлөх заавар ба буцаан олголтын журам	16P
8.	Виза (VISA)-тай холбоотой мэдээлэл	17P
9.	Бусад	18P
10.	Маягт[танилцах]	19P

[Зайлшгүй унших] Элсэгчдэд тавигдах нийтлэг шаардлага

Мэдээлэл болон зарлалын талаар их сургуулийн төгсөлтийн сургуулийн албан ёсны вэбсайт (<http://gs.shinhan.ac.kr>)-д тогтмол нийтэлнэ.

Зарлалын талаарх мэдээллийг шалгах Үүрэг нь зөвхөн өргөдөл гаргагчид хамаарах бөгөөд мессеж мэдэгдэл нь сургуулиас Үзүүлж буй нэмэлт Үйлчилгээ юм. Зарлалыг хянаагүйгээс Үүдэн гарах аливаа хариуцлагыг өргөдөл гаргагч өөрөө БҮрэн хариуцах бөгөөд энэ талаар сургууль ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болохыг анхаарна уу.

1. Элсэлтийн шалгаруулалтын зөрчилд авах арга хэмжээ

① Тавигдах шаардлагыг хангаагүй өргөдөл гаргагч, мөн БҮрдүүлэх материалыг худал мэдүүлсэн, өөрчилсөн, эсхүл бусад хууль бус Үйлдэл гаргасан нь тогтоогдсон тохиолдолд элсэлтийн эрхийг цуцлах буюу сургуулийн БҮртгэлийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд БҮртгэлийн хураамж болон төлсөн сургалтын төлбөрийг буцаан олгохгүй болно.

2. Бусад анхаарах

① Элсэлтийн хугацаанд **төгсөхөөсөө өмнө** төгсөх төлөвтэй гэсэн тодорхойлолт(эсвэл зэрэг олгох төлөвтэй гэсэн тодорхойлолт) болон сүүлийн улирлын дүн ороогүй дүнгийн тодорхойлолт ирүүлсэн тохиолдолд, **төгссөн даруйдаа төгссөн тодорхойлолт (эсвэл зэрэг авсан тодорхойлолт)** болон сүүлийн улирлын дүн орсон **эцсийн дүнгийн хуулбарыг тус бүр нэг хувийг заавал их сургуулийн төгсөлтийн албанд** ирүүлэх шаардлагатай.

② БҮртгэлийн хураамжийн төлбөр төлөөгүй болон баримт бичиг дутуу өргөдлийг хүлээн авах боломжгүй.

③ БҮрдүүлэх материалыг огт ирүүлээгүй буюу дутуу ирүүлсэн тохиолдолд шалгаруулалтаас хасна.

④ БҮртгүүлсэн өргөдлийг цуцлах буюу өөрчлөх боломжгүй бөгөөд, БҮртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

⑤ Элсэлтийн шалгаруулалтын дүнг нийтэд зарлахгүй бөгөөд, **ирүүлсэн бичиг баримтыг буцаан олгохгүй.**

⑥ БҮртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг **эх хувиар** нь БҮрдүүлэх нь Үндсэн зарчим бөгөөд, зайлшгүй хуулбарыг өгөх шаардлагатай бол эх хувийг авчирч Шинхан Их Сургуулийн төгсөлтийн албанд **эх хувийн баталгаажуулалт хийлгэсний** дараа БҮртгүүлэх шаардлагатай. Мөн заавал эх хувиар ирүүлэх шаардлагатай баримт бичиг байгаа тохиолдолд, эцсийн БҮртгэл хийх Үед **уг баримт бичгийн эх хувийг нэмэлтээр ирүүлэх** шаардлагатай.

※ **Гадаадын баримт бичгийг солонгос (эсвэл англи) хэл рүү орчуулж, нотариатаар баталгаажуулсан баримтыг** тусад нь БҮрдүүлэн өгөх шаардлагатай.

⑦ **Овог, нэр болон иргэний БҮртгэлийн дугаар** нь заавал иргэний БҮртгэлд бичигдсэн мэдээлэлтэй ижил байх ёстой. Харин хаяг, утасны дугаар нь элсэлтийн хугацаанд ашиглагдах тул **өөрчлөгдсөн тохиолдолд их сургуульд даруй мэдэгдэж шинэчлэх** шаардлагатай.

⑧ БҮртгэл хийгдэж дууссаны дараа өргөдлийн мэдээллийг засах буюу цуцлах боломжгүй тул **ГЭЛСЭЛТИЙН ЖУРАМЫГ САЙТАР СУДАЛЖ** элсэлтийн төрөл, хүсэлт гаргасан мэргэжил, шалгуур нөхцлийг зөв оруулсны дараа хянан шалгаж БҮртгүүлэх шаардлагатай.

⑨ Хэрэв өргөдөл гаргагч нь **тус Шинхан академийн ажилтан(багш, ажилтан)-ы гэр бүлийн гишүүн(эхнэр, нөхөр эсвэл төрсөн хүүхэд) бол ажил эрхлэлтийн тодорхойлолт болон гэр бүл харилцааг батлах бичиг-г** БҮрдүүлж өгөх шаардлагатай.

⑩ Өргөдөл гаргагчийн дунд хууль ёсны хамаарал бүхий энэ сургуулийн ажилтан байгаа бол тухайн ажилтанд заавал мэдэгдэх ёстой. Мэдэгдсэн ажилтан нь ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх Үүднээс оруулалтаас татгалзах буюу хяналтаас чөлөөлөх Хүсэлт гаргах шаардлагатай.

⑪ Тус сургуулийн ажилтны өргөдөл гаргагчийн хувьд харьяа хэлтсийн **даргын зөвшөөрлийг** авсны дараа **эцсийн шатанд ерөнхий захирлын зөвшөөрөл** шаардагдана.

⑫ Гадаад оюутны шалгаруулалтад тэнцэж БҮртгүүлсэн хүнээс боловсролын лавлагааны шалгалтаар хууль зөрчсөн зүйл илэрвэл элсэлтийг цуцална.

⑬ Гадаад оюутнууд **төгсөх ХҮртлээ Солонгос хэлний чадварын шалгалт (ТОPIK) 4 түвшинг (гэхдээ давхар хэлний хөтөлбөр болон урлаг спортын чиглэлийн оюутнуудын хувьд 3-р түвшинг) авах** шаардлагатай.

⑭ Шалгарсан хүмүүсийг их сургуулийн албан ёсны вэбсайт дээр зарлана.(Хувь хүн тус бүрт тусгай мэдэгдэл хийгдэхгүй)

⑮ * Хятад оюутнууд суралцах хугацаандаа **Хятадын Боловсролын яамнаас тогтоосон алсын зайны сургалтын шалгуур болон Солонгост байршлын хугацааг хангахгүй бол**, Хятад **CSCSE (Боловсролын яамны гадаад суралцагчийн Үйлчилгээний төв, гадаадад авсан зэрэг бичиг баталгаажуулах байгууллага)** нь гадаадад авсан дипломын гэрчилгээний баталгаажуулалтад асуудал үүсгэж болзошгүй тул анхаараарай.

* Алсын зайны сургалтыг бүх гадаад оюутнууд **жилд авах ёстой.**

1

Элсэлтийн хуваарь

Ангилал	Хугацаа	Агуулга									
Онлайн бүртгэл	2026.05.15.(ба) 12:00 ~ 2026.05.26.(мяг) 18:00	- Онлайн бүртгэл (http://www.jinhakapply.com) - Сургуулийн бүртгэлийг зөвхөн онлайнаар хийнэ, биечлэн бүртгэл авахгүй									
Материал хүлээлгэн өгөх	2026.05.15.(ба) ~ 2026.05.27.(лха)	- Интернэт бүртгэлийн сайт(Jinhak Apply)-аас дугтуйн шошгыг хэвлэж, шаардлагатай бичиг баримтыг хамтатган шалгасны дараа дугтуйнд нааж илгээнэ. - Бүрдүүлж өгсөн баримт бичгийг буцаан олгохгүй <table border="1"> <tr> <td>Бүрдүүлж өгөх арга</td><td>Биечлэн ирэх</td><td>Баримт бичиг өгөх эцсийн хугацаа хүртэл хүчинтэй</td></tr> <tr> <td></td><td>Баталгаат шуудан</td><td>2026 оны 05 сарын 27 ны (лха) 18:00 өмнө ирсэн материалыг хүчинтэйд тооцно</td></tr> <tr> <td colspan="2">Хүлээн авах газар</td><td>(Шуудангийн код: 11644) БНСУ, Гёнгидо аймаг, Ыйжонбу хот, Хоамро гудамж 95, Шинхан Их Сургууль, Сион байрны 4 давхар, сургуулийн сургалтын алба, Элсэлт хариуцсан ажилтан</td></tr> </table>	Бүрдүүлж өгөх арга	Биечлэн ирэх	Баримт бичиг өгөх эцсийн хугацаа хүртэл хүчинтэй		Баталгаат шуудан	2026 оны 05 сарын 27 ны (лха) 18:00 өмнө ирсэн материалыг хүчинтэйд тооцно	Хүлээн авах газар		(Шуудангийн код: 11644) БНСУ, Гёнгидо аймаг, Ыйжонбу хот, Хоамро гудамж 95, Шинхан Их Сургууль, Сион байрны 4 давхар, сургуулийн сургалтын алба, Элсэлт хариуцсан ажилтан
Бүрдүүлж өгөх арга	Биечлэн ирэх	Баримт бичиг өгөх эцсийн хугацаа хүртэл хүчинтэй									
	Баталгаат шуудан	2026 оны 05 сарын 27 ны (лха) 18:00 өмнө ирсэн материалыг хүчинтэйд тооцно									
Хүлээн авах газар		(Шуудангийн код: 11644) БНСУ, Гёнгидо аймаг, Ыйжонбу хот, Хоамро гудамж 95, Шинхан Их Сургууль, Сион байрны 4 давхар, сургуулийн сургалтын алба, Элсэлт хариуцсан ажилтан									
Баримт бичгийн шалгалт	2026.06.01.(да) ~ 2026.06.02.(мяг)	Бичиг баримт бүрдүүлэн өгөх Үед ирүүлсэн дүнгийн хуулбар болон суралцах төлөвлөгөөг Үнэлж, шалгалт явуулна									
Тэнцсэн элсэгчдийн нэрсийн жагсаалт	2026.06.30.(мяг) 14:00 урьдчилсан төлөв	Сургуулийн цахим хуудас(http://gs.shinhan.ac.kr/)-аас шалгах									
Сургалтын төлбөрийн төлөлт	2026.07.01.(лха) 09:00 ~ 2026.07.03.(ба) 16:00	- Тэнцсэн эсэхийг шалгасны дараа төлбөрийн нэхэмжлэлийг хэвлэж, төлбөрийг төлнө - Бүртгэлийн төлбөр төлөх газар : Kookmin банкны бүх салбар болон дансанд шилжүүлэг хийх [Банкны ажлын цаг (09:00–16:00)-аас гадуур шилжүүлэг хийх боломжгүй] - Сургалтын төлбөр төлөх арга : Сургуулийн вэб сайтад нийтлэгдсэн мэдэгдлээс харна уу									

※ Дээр дурдсан хуваарьт зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын улмаас өөрчлөлт орох боломжтой.

※ Тэнцсэн тухай мэдээллийг тусгайлан мэдэгдэхгүй тул манай сургуулийн вэб сайт (<http://gs.shinhan.ac.kr/>)-аас шалгах шаардлагатай. Хэрэв шалгаагүйгээс Үүдэн элсэлтийг цуцлах зэрэг ямар нэгэн хохирол учирвал уг хариуцлагыг бүртгүүлэгч өөрөө хүлээнэ. Иймд анхаарал хандуулахыг хүсье.

※ Солонгос хэлний дотоод шалгалтын хуваарь болон дэлгэрэнгүй мэдээллийг Шинхан Их Сургуулийн Олон улсын хэлний төвөөс лавлана уу.

☎ 031)870-3563

2

Элсэгч авах нэгж болон бҮртгҮҮлэгчийн шалгуур

1 Ерөнхий мэргэжлийн сургууль

(x: Элсэлт байхгүй, / : Байгуулагдаагүй)

Ангилал	Тэнхим	Мэргэжил	Элсэх хөтөлбөр				Бусад
			Шинэ элсэлт		Шилжин суралцах (3 улирал)		
			Магистр	Доктор	Магистр	Доктор	
ХҮмҮҮнлэг, нийгмийн ухаан	ОУ хөгжлийн хамтын ажиллагаа	ОУ хөгжил хамтын ажиллагаа					
		Хиймэл оюун ухаан гадаад хэлний орчуулагч	○	○	○	○	
	Нийгмийн халамж	Нийгмийн халамж					
		Нийгмийн халамжийн бодлого	○	○	○	○	
		ЭмнэлзҮйн нийгмийн халамж					
	Төрийн удирдлагын бодлого	Төрийн удирдлага					
		Цагдаагийн криминалистикийн судлал	○	○	○	○	
		Улс төр судлал					
	ОУ бизнес	Бизнесийн удирдлага					Хоёр хэлний боловсролын хөтөлбөр
		ОУ бизнесийн удирдлага	○	○	○	○	
		Соёл урлагийн менежмент					
	Нэгдсэн менежментийн тэнхим	Олон улсын MBA мэргэжил	○		×		1 жилийн хөтөлбөртэй элсэлт
	Зочид буудал, аялал жуулчлалын менежмент	Зочид буудал хҮнс технологийн удирдлага					
		DMZ аялал жуулчлалын бодлого судлал	○	○	○	○	
		Аялал жуулчлалын контент менежмент					
Нэгдсэн боловсрол	Боловсролын сэтгэл зҮйн мэргэжил					Хоёр хэлний боловсролын хөтөлбөр	
	Боловсролын инженерчлэл						
	Боловсрол судлал Боловсролын удирдлага	○	○	○	○		
	Бага насны хҮҮхдийн боловсрол						
	Солонгос хэл заах арга зҮй						
Урлагийн сэтгэл судлал ба эмчилгээ	Урлагийн сэтгэл зҮйч /silvercare/	○	○	○	○		
	ХҮҮхдийн боловсролын зөвлөх						
Байгалийн шинжлэх ухаан	Интегратив болон алтернатив анагаах ухаан	Физик эмчилгээ бариа заса/chiropractic/					
		Сэтгэцийн эрҮҮл мэндийн	○	○	○	○	
		ЭрҮҮл ахуй анагаах ухаан					
	ЭрҮҮл мэндийн технологи	Радиологи эмнэлгийн тоног төхөөрөмж					Ижил чиглэлээр элсэх
		ШҮдний технологич					
		ШҮдний эрҮҮл ахуйч	○	○	○	○	
		ЭмнэлзҮйн эмгэг судлал					
	Био хҮнс аж Үйлдвэрлэлийн тэнхим	Оптометрийн судлал /нҮдний шил/					
		Био хҮнс судлал					
		ХҮнсний аж Үйлдвэрлэл	○	○	○	○	
Сувилахуй	Алтернатив хҮнс боловсруулалт					Ижил чиглэлээр элсэх	
	Сувилахуй	○	○	○	○		

Салбар	Тэнхим	Мэргэжил	Элсэх хөтөлбөр				Бусад
			Шинэ элсэлт		Шилжин суралцах (3 улирал)		
			Магистр	Доктор	Магистр	Доктор	
Инженерийн чиглэл	ICT механик тоног төхөөрөмж	Термодинамик ба шингэний механик судлал	○	○	○	○	Ижил чиглэлээр элсэх
		Механик Үйлдвэрлэлийн инженерчлэл					
	Барилга байгаль орчны шинжлэх ухаан	Smart зам гүүр орчны инженерчлэл	○	○	○	○	
		Smart барилгын инженер					
		Байгаль орчны уур амьсгал					
		Хот төлөвлөлт ба Үл хөдлөх хөрөнгө					
	Кибер хамгаалалт	Кибер батлан хамгаалалт	×		×		
	Батлан хамгаалахын программ хангамж	Батлан хамгаалах программ хангамж	×		×		
Урлаг, спортын чиглэл	Спорт, ЭрҮҮл мэнд	Дасгал хөдөлгөөн сэргээн засалч	○	○	○	○	Хоёр хэлний боловсролын хөтөлбөр
		Спортын дасгалжуулагч ба аж Үйлдвэр судлал					
		Тусгай спортоор нөхөн сэргээх эмчилгээ					

※ Зарим хөтөлбөрийн хувьд өмнөх зэрэглэлийн мэргэжил нь элсэх гэж буй чиглэлээс ялгаатай байсан ч элсэлтийг өргөдөл гаргах боломжтой. (Гэхдээ тухайн чиглэлд шаардагдах суурь хичээлийг судлах шаардлага ҮҮснэ.)

2 Тусгай зориулалтын магистр, докторын сургууль (Полиматес сургууль)

Салбар	Тэнхим	Мэргэжил	Элсэх хөтөлбөр		Бусад
			Магистр	Доктор	
Урлаг, спортын чиглэл	Гоо сайхан, Загвар дизайн	Гоо сайхан дизайн	○		
		Загварын технологи	×		
	K-Соёлын ухаан	K-рор контент бҮтээл	○		
		K-food контент бҮтээл	○		
		K-тайквондо	○		
	Гольф болон парк гольфын ухаан	Гольф ба Парк гольф	○		

3 Тавигдах шаардлага

① Гадаад иргэдийн элсэлтийн тавигдах шаардлага болон ② Боловсролын зэрэглэлээр тавигдах шаардлага, ③ Хэлний ур чадварын **бҮх шаардлагыг хангасан** байх ёстой.

① Гадаад иргэдийн элсэлтийн тавигдах шаардлага

Ангилал	Тавигдах шаардлага
Элсэх эрх	Эцэг, эх нь хоёулаа гадаадын иргэн байх
Анхаарах зүйл	Өргөдөл гаргагч эсвэл түүний эцэг эхийн аль нэг нь БНСУ-ын иргэншил бҮхий давхар иргэншилтэй бол элсэлтийн бҮртгэл хийхийг хориглоно. Давхар иргэншилтэй нь батлагдсан тохиолдолд, элсэлтийг хҮчингүй болгоно.

② Тухайн боловсролын зэрэгт хамаарах элсэлтийн шаардлага

- Шинэ элсэлт

Ангилал	Тавигдах шаардлага	
Боловсролын зэрэг	Магистр	• Дотоод, гадаадын их, дээд сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан эсвэл 2026 оны 2-р сар хүртэл төгсөх боломжтой хүн • Холбогдох хууль, дүрмийн хүрээнд бакалаврын зэрэгтэй адилтгах буюу түүнээс өндөр боловсрол эзэмшсэн гэж үзэх боломжтой хүн
	Доктор	• Дотоодын болон гадаадын их сургуулиудад магистрын зэрэг авсан, эсвэл 2026 оны 2-р сар хүртэл төгсөх боломжтой хүн • Холбогдох хууль, дүрмийн хүрээнд магистрын зэрэгтэй адилтгах буюу түүнээс өндөр боловсрол эзэмшсэн гэж үзэх боломжтой хүн

- Шилжин суралцах
- Дотоод болон гадаадын их сургуулийн хөтөлбөрт (ижил эсвэл төстэй мэргэжлээр) 2 улирал (12 кредит)-с дээш суралцсан хүн
- Хөтөлбөрийн ангиллаас хамаарсан шилжин суралцах эрхийн шаардлага

Боловсролын зэрэг	Шилжин суралцах семестр	Шилжин ирэхээс өмнөх их, дээд сургууль		Дүйцүүлэх кредит
		Бүртгэгдсэн семестр	Суралцсан кредит	
Магистр болон Доктор	3 семестр	2 семестр дээш	12 кредит дээш	Хамгийн ихдээ 12 кредит

※ Өмнөх сургуулийн кредит хүлээн зөвшөөрөх байдлаас шалтгаалан шилжин суралцсаны дараа нэмэлт семестр шаардлагатай болж болзошгүй тул анхаарна уу.

※ Шилжин суралцах тохиолдолд зөвхөн ижил чиглэлээр элсэлт авна

③ Хэлний мэдлэг

Ангилал	Тавигдах шаардлага
Хэлний мэдлэг	• Доорх хэлний мэдлэгийн шаардлагын аль нэгийг хангасан хүн
	① Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK, TOPIK IBT)-н 3-р түвшин болон түүнээс дээш түвшин авсан хүн
	② Тус сургуулийн солонгос хэлний сургалтын 4-р түвшин буюу түүнээс дээш түвшнийг амжилттай төгссөн (1 жилээс дээш суралцсан)
	③ Тус сургуулийн олон улсын хэлний төвөөс зохион байгуулдаг солонгос хэлний дотоод шалгалтад амжилттай тэнцэгч
	④ Хоёр хэлний сургалтын хөтөлбөрт элсэх эрхийн шаардлагыг манай сургуулийн магистрын зөвлөл тусгайлан хянан үзнэ
	⑤ Нийгмийн нэгдсэн хөтөлбөр (KIP)-ийн 3-р шат болон түүнээс дээш түвшнийг амжилттай судалсан эсвэл урьдчилсан шалгалтад 61 ба түүнээс дээш оноо авсан бол
	⑥ Сэжон хүрээлэнгийн солонгос хэлний сургалтын дунд шатны 1-р түвшин болон түүнээс дээш түвшнийг амжилттай судалсан байх (онлайн сургалтыг хүлээн зөвшөөрөхгүй)

※ Хос хэлтэй элсэлтийг сонгож элссэн элсэгч: Элссэнээс хойш солонгос хэлний хичээл *300 цагийн солонгос хэлний сургалтад заавал хамрагдах шаардлагатай

※ Сургуульд элссэний дараа төгсөхөөс өмнө TOPIK 4-р түвшин заавал авах шаардлагатай (харин хоёр хэлний сургалтын хөтөлбөр болон урлаг, спортын чиглэлээр суралцагчдын хувьд 3-р түвшин байж болно)

3

Шалгаруулалтын аргачлал

1 Гадаад оюутны элсэлт шалгаруулалтын аргачлал(элсэгчийн тооны хязгааргүй)

- Гадаад оюутны шалгаруулалтыг өргөдөл гаргагчийн ирүүлсэн бичиг баримтад тулгуурлан Үнэлгээний хуудасны дагуу 100%-ийн харьцаатайгаар дүгнэнэ
- Элсэлтийн тооноос Үл хамааран, суралцах чадвар хангалтгүй гэж Үнэлэгдсэн тохиолдолд тэнцээгүйд тооцно
- Шаардлагатай бичиг баримтыг ирүүлээгүй тохиолдолд өргөдөл гаргагчийг тэнцээгүйд тооцно

Салбар	Шалгаруулалтын аргачлал	Бусад
БҮх мэргэжлийн чиглэл	Бичиг баримт 100%	▪ Өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн шалгалт ▪ Элсэлтийн тооноос Үл хамааран сургалтын амжилтын чадвар хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд* тэнцэхгүй гэж Үзнэ ▪ Шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд өргөдөл гаргагчийг тэнцээгүйд тооцно

* Гадаад иргэний бичиг баримтын шалгаруулалтын Үнэлгээний Үзүүлэлт тус бүрд хангалтгүй гэж Үнэлэгдсэн тохиолдолд

4 Бичиг баримт бҮрдҮҮлэх заавар

1 Бичиг баримт бҮрдҮҮлэх заавар

- Анхаарах зҮйлс (нийтлэг)
- Төгсөх ангийн оюутан нь 2026.08.31. (да) өдрөөс өмнө бакалавр (эсвэл магистр)-ын диплом болон дҮнгийн хуулбарыг төгсөлтийн дараах сургуульд заавал ирҮҮлэх ёстой.

2 Нийтлэг бҮрдҮҮлэх бичиг баримт (БҮх баримт бичиг нь солонгос/англи хэл дээрх эх хувь мөн албан ёсны баталгаат орчуулгатай байх шаардлагатай)

Дэс дугаар	Үндсэн бичиг баримт	Боловсролын зэрэг		Анхаарах зҮйл
		Магистр	Доктор	
1	Онлайн бҮртгэл хийгдсэн бҮртгэлийн хуудас	○	○	• Өргөдлийн маягтыг бөглөсний дараа хэвлэн, холбогдох байгууллагад ирҮҮлэх шаардлагатай
2	Их сургуулийн төгссөн (төгсөх гэж байгаа) тухай тодорхойлолт	○	○	[4-а. Нэмэлт баримт бичиг бҮрдҮҮлэх заавар – Эцсийн боловсролыг баталгаажуулах баримт бичиг]
3	Магистр их сургуулийн төгссөн (төгсөх гэж байгаа) тухай тодорхойлолт	×	○	• Дотоодын их, дээд сургууль: Төгссөн (эсвэл төгсөхөөр төлөвлөсөн) тухай гэрчилгээ ※ Баримт бичгийн баталгаажуулалтын дугаараар шалгах боломжтой байх ёстой. • Их, дээд сургууль - Апостиль (apostille) ийн эх хувь - Консулын баталгаажуулсан эх хувь - (БНХАУ-д байрлах их, дээд сургууль) CHSI-с олгосон эх хувь <Анхаарах зҮйлс> • Төгсөхөөр төлөвлөсөн тухай гэрчилгээ: Төгсөх огноо заавал тусгагдсан байх шаардлагатай. • Бакалаврын шилжин элсэгч: Шилжин элсэхээс өмнөх болон дараах их, дээд сургуулийн баримт бичгийг хоёуланг нь заавал бҮрдҮҮлнэ. • Докторын сургалтын хөтөлбөрт өргөдөл гаргагч: Бакалавр (мэргэжлийн бакалавр орно) болон магистрын зэрэг олгосон баримт бичгүүдийг бҮгдийг нь бҮрдҮҮлэн ирҮҮлэх шаардлагатай.
4	Их сургуулийн дҮнгийн тодорхойлолт	○	○	• Дотоодын их, дээд сургууль: ДҮнгийн тодорхойлолт ※ Баримт бичгийн баталгаажуулалтын дугаараар шалгах боломжтой байх ёстой.
5	Магистр их сургуулийн дҮнгийн тодорхойлолт	×	○	• Гадаадын их, дээд сургууль - Апостиль (apostille) ийн эх хувь - Консулын баталгаажуулсан эх хувь - ((БНХАУ-д байрлах их, дээд сургууль) ДҮнгийн тодорхойлолтын орчуулга ба нотариатаар баталгаажуулсан англи хувилбар. <Анхаарах зҮйлс> • Бакалаврын шилжин элсэгч: Шилжин элсэхээс өмнөх болон дараах их, дээд сургуулийн баримт бичгийг хоёуланг нь заавал бҮрдҮҮлэн ирҮҮлэх шаардлагатай. • Докторын сургалтын хөтөлбөрт өргөдөл гаргагч: Бакалавр (мэргэжлийн бакалавр орно) болон магистрын сургалтын дҮнгийн тодорхойлолтыг бҮгдийг нь бҮрдҮҮлэн ирҮҮлэх шаардлагатай.
6	Өргөдөл гаргагч болон тҮҮний эцэг/эхийн гадаад улсын иргэншлийг нотлох баримт бичиг	○	○	• Өргөдөл гаргагч болон эцэг, эхийн гадаад паспортын хуулбар(мөн иргэний Үнэмлэхийн хуулбар) ирҮҮлэх



7	Гэр бүлийн харилцаа холбоог нотлох баримт бичиг	○	○	• Өргөдөл гаргагчийн төрсний гэрчилгээ, гэр бүлийн бүртгэлийн лавлагаа, оршин суугчийн бүртгэлийн лавлагаа, төрөл садны тодорхойлолт зэрэг өргөдөл гаргагч болон эцэг эхийн харилцааг нотлох баримт бичиг (баталгаат орчуулгатай байх шаардлагатай) • БНХАУ-ын иргэн: Хүн амын бүртгэлийн гэрчилгээ/ орчуулгын баталгаажуулалттай ирүүлэх Хэрэв Хукоу тусдаа бол эцэг, эх, өргөдөл гаргагчийн Хукоу болон гэр бүлийн харилцааг нотлох бичиг баримтыг баталгаажуулан ирүүлэх шаардлагатай. ※ Эцэг, эхийн аль нэг нь байх тохиолдолд ① Нас барсан тухай гэрчилгээ эсвэл гэр бүл цуцлалт нотлох баримт бичиг ② Эцэг, эхийн гэрлэлт бүртгэл нотлох баримт бичиг
8	Гадаад паспорт хуулбар	○	○	• Өөрийн
9	Гадаад цэнхэр Үнэмлэхийн хуулбар	○	○	• Өөрийн (БНСУ-д оршин суугаа гадаадын иргэнд хамаарна)
10	Солонгос хэлний мэдлэгийн тодорхойлолт	○	○	[4-а. Нэмэлт бичиг баримт бүрдүүлэх заавар – Хэлний мэдлэгийн батламж] ※ Хоёр хэлний сургалтын хөтөлбөр шаардлагагүй
11	Суралцах төлөвлөгөө болон боловсролын байдлын лавлагаа	○	○	• Сургуулийн тогтоосон маягт
12	Санхүүгийн чадварыг баталгаажуулах баримт бичиг	○	○	4-а. Нэмэлт бичиг баримт бүрдүүлэх заавар – [Санхүүгийн чадавхыг баталгаажуулах баримт бичиг] лавлагаа

А. Нэмэлт баримт бичиг ирүүлэх заавар

1 СҮҮлийн боловсролын гэрчилгээ / дипломын батламжийн баримт бичиг

Салбар	Бүрдүүлэх бичиг баримт
Апостильд нэгдсэн улсын иргэн	• Бүрдүүлэх бичиг баримт: Төгссөн сургууль / дипломын батламжид холбогдох Апостиль батламж ※ Апостиль (Apostille): Сургуулийн байрлаж буй улсын эрх бүхий байгууллагаас олгогдсон байна.
Хятад	• Бүрдүүлэх бичиг баримт: CHSI-аар олгосон англи хэлний боловсролын батламжийн баримт бичиг эсвэл Апостиль батламж ※ Хэрэв Апостиль батламжийг өгөөгүй тохиолдолд доорх баримт бичгүүдийг тус бүр 1 хуудсаар бүрдүүлнэ: 1. Боловсролын батламжийн төвийн(http://www.chsi.com.cn)англи хэлний дипломын батламж (Online Verification Report of Higher Education Degree Certificate) хэвлэмэл хувилбар 2. Төгссөн гэрчилгээгийн (диплом) англи хэл рҮҮ орчуулсан нотариатаар баталгаажуулсан хувилбар 3. Дипломын англи хэл рҮҮ орчуулсан нотариатаар баталгаажуулсан хувилбар
Япон	2026 оны 3-р сард төгсөх бөгөөд хичээлийн эхлэх өдрөөс хойш 8 долоо хоногийн дотор сүүлийн боловсролын гэрчилгээ (Апостиль заавал шаардлагатай)
Апостильд нэгдээгүй улсын иргэн	• 2026 оны 3-р сард төгсөх бөгөөд хичээлийн эхлэх өдрөөс хойш 8 долоо хоногийн дотор сүүлийн боловсролын гэрчилгээ (Апостиль заавал шаардлагатай) • Олгогч байгууллага: Сургуулийн байршиж буй улсын Солонгос дахь консул эсвэл Солонгос дахь элчин сайдын яамны консул
Лавлах зүйлс	Бичиг баримт бүрдүүлэх Үед төгсөх төлөвтэй суралцагчийн хувьд: Төгссөн (диплом авсан) дараа заавал сүүлийн боловсролын гэрчилгээ / дипломын батламж болон сүүлийн семестрийн дүнгийн тодорхойлолтыг бүрдүүлэн өгөх шаардлагатай.


[Лавлах1] СҮҮлийн боловсролыг баталгаажуулах бичиг баримтын жишээ




[Лавлах2] Боловсролыг баталгаажуулах аргачлал

• Апостиль (Apostille) батламж олгох журам

- Албан бичиг баримт (төрийн / нийтийн сургууль гэх мэт)



- Хувийн бичиг баримт (хувийн сургууль гэх мэт)



※ Апостиль гэрээ, Апостиль батламж, гэрээний оролцогч улс зэрэг мэдээллийг дараах газраас нарийвчлан лавлах боломжтой: (<http://www.hcch.net>) ,

Гадаад харилцаа, худалдааны яамны "Гадаадад аялах аюулгүй байдал" веб сайт (<http://www.0404.go.kr>)

Мөн тусгай зөвлөгөө авах болон лавлагаа авах утас

Үндсэн зөвлөгөө (02-2100-7500), Консулын колл төв (02-3210-0404) нарийвчлан лавлах боломжтой

- Консулын баталгаажуулалт: Сургуулийн байрлаж буй улсын Солонгос дахь консу эсвэл Солонгос дахь элчин сайдын яамны консул баталгаажуулалт
- Хятадын боловсролын яамнаас олгосон боловсрол, дипломын батламжийн тайлан (зөвхөн Хятадад байрлах их сургуулийн суралцагчдад): Хаосин Ван(学信网)
 - Баталгаажуулах байгууллагын нэр: 教育部学生服务与素质发展中心
 - Веб сайт: <http://www.chsi.com.cn>
 - Утасны дугаар: +86-10-6741-0388
 - ※ Солонгосоос батламжийн тайлан авах хҮсэлтэй тохиолдолд
[СөҮлийн Конфуци академи]-с хҮсэлт гаргаж болно
 - Веб сайт: <http://renew.kongzi.co.kr> Хятадын боловсролын батламж
 - Утас: +82-2-554-2688, имэйл: cis88@cis.or.kr

2 Хэлний чадварыг баталгаажуулах баримт бичиг

- Дараах баримт бичгүүдийн аль нэгийг ирүүлэх

Ангилал	Баталгаажуулах бичиг баримт
Солонгос хэлний тҮвшин тогтоох шалгалт(ТОPIK)	Солонгос хэлний тҮвшин тогтоох шалгалтын (ТОPIK) дҮнгийн тодорхойлолт (ТОPIK IBT шалгалтын дҮнгийн тодорхойлолт)
Сэжон ХҮрээлэнгийн солонгос хэлний сургалт	Сэжон хҮрээлэнгийн төгсөлтийн гэрчилгээ (дунд шат 1 буюу тҮҮнээс дээш)*
Хууль зҮйн яамны НийгэмшҮҮлэх хөтөлбөр(KIIP)	3 ба тҮҮнээс дээш тҮвшнийг амжилттай төгссөн тухай гэрчилгээ эсвэл 3-с дээш оноотой Үнэлгээний хуудас
Тус сургуулийн хэлний бэлтгэлийн төгсөгч	4 ба тҮҮнээс дээш тҮвшний төгсөлтийн гэрчилгээ (1 ба тҮҮнээс дээш жилийн сургалт)
Дотоод шалгалтад тэнцсэн элсэгч	Дотоодын шалгалтад тэнцсэн тодорхойлолт

* ① Онлайн сэжон хҮрээлэнгийн төгсөлтийн гэрчилгээ, ② БНСУ-д оршин суугаа гадаадын иргэдийн хувьд онлайн Сэжон ХҮрээлэнгийн хөтөлбөрийг дҮҮргэсэн тохиолдолд хҮлээн зөвшөөрөхгүй

3 СанхҮҮгийн чадварыг нотлох баримт

Үндсэн бичиг баримт	БҮрдҮҮлэх бичиг баримт
СанхҮҮгийн чадварыг нотлох баримт	• Өөрийн эсвэл санхҮҮгийн батлан даагчийн банкны Үлдэгдлийн тодорхойлолт эсвэл дотоодын мөнгөн гуйвуулгын баталгаа гэх мэт - Өргөдөл гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргасан байх. Гэхдээ хҮчинтэй хугацаа нь заасан банкны Үлдэгдлийн тодорхойлолтын хувьд, тухайн хҮчинтэй хугацаа дуустал хҮчин төгөлдөрт тооцогдох боловч, гаргасан өдрөөс хойш хамгийн ихдээ 6 сар хҮртэлх хугацаанд хҮчинтэйд тооцно. ① Солонгос улсад шинэ виз мэдҮҮлэх Үед, тухайн виз мэдҮҮлэгч нь банкны дансандаа 20,000,000 воноос дээш мөнгө байршуулах шаардлагатай. ② Солонгост оршин суугаа хҮн оршин суух хугацаагаа сунгах эсвэл оршин суух ангиллаа өөрчлөх Үед: 10 сая воноос дээш хадгаламжтай байх шаардлагатай. • СанхҮҮгийн чадварыг нотлох баримт нь өөрийн нэр дээр биш бол: СанхҮҮгийн батлан даагчийн дараах баримтуудыг бҮрдҮҮлнэ ① Ажил эрхэлж буйг батлах баримт - ажил эрхлэлтийн тодорхойлолт эсвэл бизнесийн гэрчилгээ, ② Хөрөнгийн баримт ③ Гадаадад суралцах зардлыг хариуцах баталгааны бичиг<Сургуулийн тогтоосон маягын дагуу> г.мэт

4 (Шилжин суралцах) Боловсролын зэрэгтэй холбоотой нэмэлт бичиг баримт

Ангилал	БҮрдүүлэх бичиг баримт	
Ижил боловсролын зэрэгтэй холбоотой суралцаж буйг батлах тодорхойлолт	• Дараах баримт бичгүүдийн аль нэгийг ирүүлэх ① Төгссөн тодорхойлолт ② Төгсөх тодорхойлолт ③ Суралцаж буй тодорхойлолт	• Дотоодын их сургууль: Цахимаар олгосон дугаар бүхий эх хувийн гэрчилгээг ирүүлэх (3 сарын дотор олгосон байх) • Гадаадын их сургууль: Солонгос эсвэл англи хэлээр орчуулагдсан эх хувийн нотариатаар баталгаажуулсан баримт бичгийг ирүүлэх • (Нийтлэг) Тодорхойлолт дотор сурсан улирлыг баталгаажуулсан байх шаардлагатай.
	Дүнгийн тодорхойлолт	

※ **Гадаадын их сургуулийн нотариатаар баталгаажуулсан баримт бичиг:** сургуулийн байрладаг улсын

Апостиль (Apostille) баталгаажуулсан баримт бичиг эсвэл тухайн улсын БНСУ дахь Элчин сайдын яамны (эсвэл БНСУ-ын Элчин сайдын яам) баталгаажуулсан бичиг

5

Онлайн элсэлтийн бҮртгэлийн аргачлал болон шалгаруулалтын хураамжийн дэлгэрэнгүй мэдээлэл

1. Онлайн элсэлтийн бҮртгэлийн шат дамжлага

Сургуулийн албан ёсны вэб сайтад нэвтрэх (<http://gs.shinhan.ac.kr>)



Хуудасны дээд хэсэгт төгсөлтийн дараах сургуулийг сонгосны дараа доод хэсэгт байрлах [БҮртгэлийн маягт бөглөх] товчийг дарна уу



Нэвтрэх



Анхаарах зүйлсийг нягталж, БҮртгэлийн маягтыг бөглөх



Шалгаруулалтын хураамж болон шимтгэлийн төлбөр хийх



Элсэлттэй холбоотой баримт бичгийг хэвлэн, шаардлагатай бичиг баримттай хамт хҮргҮҮлэх



Баримт бичгийг хҮлээн авсан байдлыг
( **제출서류확인** шалгах)

Элсэлтийн мэдээллийн самбар дахь шалгаруулалтын төрлөөр дэлгэрэнгүй

элсэлтийн удирдамжийн агуулга

JINNAK 원서접수

дарах

• БҮртгэлийн Үеэр дотоодын болон гадаадын иргэдэд зориулсан ангилал тусдаа байдаг тул заавал нягталж шалгана уу.

• Хэрэглэгчийн БҮртгэлгүй тохиолдолд гишүүнээр БҮртгҮҮлж, нэвтэрнэ ҮҮ
※Заавал өргөдөл гаргах сурагчийн хувийн мэдээллээр БҮртгҮҮлэх шаардлагатай

• Хэрэв төгсөх (эсвэл академик зэрэг авах) төлөвтэй байгаа бол тухайн зэргийн дугаар хараахан олгогдоогүй тул хоосон Үлдээх (эсвэл тҮр хугацаанд дур мэдэн оруулах боломжтой)
• БҮртгэлийн маягт дээр 3×4 хэмжээтэй зураг файлаар татаж оруулах
※ Өөрийгөө баталгаажуулах, гар утас оюутны Үнэмлэх болон бусад аргыг ашиглах
• Холбоо барих боломжтой өргөдөл гаргагчийн утасны дугаар болон бусад мэдээллийг зөв тодорхой бичих
※ Хэрэв өргөдөл гаргагчтай холбоо барих боломжгүй болсноос ҮҮдэн гарсан аливаа хохирол, асуудалд сургууль хариуцлага хҮлээхгүй.

• БҮртгэлээ баталгаажуулахын тулд заавал төлбөрөө хийсэн байх шаардлагатай
• Төлбөр төлөгдсөн БҮртгэлийг засах, цуцлах болон буцаан олгох боломжгүй.
• Шалгаруулалтын хураамжийг БҮртгэлийн Үеэр 24 цагийн турш төлөх боломжтой бөгөөд хязгаарлалтгүйгээр хҮссэн Үедээ төлбөрийг хийж болно
※ Дансны шилжҮҮлэг, кредит картын төлбөр, бэлэн бус шилжҮҮлэг, гар утасны төлбөр болон

• Онлайнгаар БҮртгҮҮлсний дараа заасан хугацаанд сургууль төгссөн (эсвэл академик зэрэг олгосон) тодорхойлолт гэрчилгээ, БҮх улирлын сурлагын тодорхойлолт, сурах төлөвлөгөө болон бусад элсэлтийн шаардлагатай баримт бичгүүдийг заавал ирҮҮлэх шаардлагатай бөгөөд ирҮҮлээгүй тохиолдолд өргөдлийг татгалзуулах болно
※ БҮртгэлийн батламж хуудсыг ирҮҮлэх шаардлагагүй

• Өргөдөл гаргагч нь өөрийн өгсөн баримт бичгүүдийн хҮрэлцээ, дутагдлыг шалгаж, БҮх баримт бичиг зөв, БҮрэн хҮрсэн эсэхийг өөрөө сайтар нягталж баталгаажуулахыг хҮсэж байна.

2 Төлбөрийн хураамж болон төлбөрийн хураамжийн буцаалт

• Төлбөрийн хураамж

Нэгж: Вон

Ангилал	Төлбөрийн хэмжээ	Онлайн бүртгэлийн шимтгэл (Шалгуулагчийн зардал)	Нийт дүн
	Гадаадын иргэдэд зориулсан элсэлт		Гадаад иргэдийн шалгаруулалт
Ерөнхий мэргэжлийн сургууль	90,000	5,000	95,000
Полимет төгсөлтийн сургууль	90,000	5,000	95,000

• Төлбөрийн хураамжийн буцаалт

- Их сургуулийн элсэлтийн шударга байдлыг хангах, мөн бусад шалгуулагчдын хохирлыг хамгийн бага байлгах зорилгоор онлайн бүртгэл дууссаны дараа өргөдөл гаргалтаа цуцлах боломжгүй. Шалгаруулалтын хураамжийг ямар ч нөхцөлд буцаан олгохгүй гэдгийг анхаарна уу. Өргөдөл гаргагч нь бүртгэлээ шалган, бүх мэдээлэл зөв, бүрэн байгаа эсэхийг сайтар нягтлах хэрэгтэй.
- Өргөдөл гаргагчийн буруугаас бус, хүчин төгөлдөр шалтгаануудаас шалтгаалан шалгалтад оролцох боломжгүй гэж тооцогдвол, баталгаажуулсан баримт бичгийг олгож, хянан үзсэний дараа хураамжийг буцаан олгох боломжтой.
 - 1) Гэнэтийн байгалийн гамшиг, өвчин, шалгаруулалтын огноонд өөрчлөлт орсон, тодорхой шалтгааны улмаас өргөдөл гаргагчийн нөхцөл байдал шаардлага хангахгүй байх зэрэг
 - 2) Бусад хувь хүний шалтгаанууд нь буцаан олгохгүй
- Сургууль Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 4 болон 5 дугаар хэсгийн дагуу элсэлтийн шалгалт дууссаны дараа элсэлтийн шалгалттай холбогдох орлого, зарлагаас Үлдсэн Үлдэгдэл ҮҮссэн тохиолдолд 2026 оны 02 сарын 28-ний дотор элсэлтийн шалгалтад оролцсон хүмүүсээс авсан элсэлтийн хураамжийг тэнцүү харьцаагаар буцаан олгох болно.
- Элсэлтийн хураамжийг буцаан олгох арга нь бүртгэлийн маягт бөглөж байх Үеийн банкны мэдээлэлд заасан данс руу шилжүүлэгдэнэ.
- Банкны данс руу шилжүүлэхдээ, буцаан олгох мөнгөн дүнгээс банкны цахим сүлжээг ашиглахад гарсан зардлыг хасна. Хэрвээ банкны цахим сүлжээг ашиглахад гарсан зардал буцаан олгох мөнгөн дүнгээс өндөр байвал буцаан олголт хийгдэхгүй.

6

Тэтгэлгийн системийн тухай мэдээлэл

1 Гадаад оюутнуудын тэтгэлэг

Ангилал		Тэтгэлэг олгох зорилтот бүлэг болон шалгуур	Тэтгэлгийн хэмжээ	Бусад
신입생	Гадаад оюутны тэтгэлэг	Гадаад оюутны элсэлтийн эрхийн дагуу элсэгч (1 жилийн богино хугацааны хөтөлбөрийн оюутнуудыг оролцуулахгүй)		
		Шинхан(신흥, 한북)их, дээд сургуулийн төгсөгчид болон сургуулийн Олон улсын хэлний албаны Солонгос хэлний хөтөлбөрийг 4 семестр (1 жил) ба түүнээс дээш хугацаанд амжилттай суралцагч	Сургалтын төлбөрийн 50%	Элсэлтийн тэтгэлэг (Элсэлтийн хураамж)
		Хоёр хэлний хөтөлбөр болон Солонгос хэлний дүйцүүлэх шалгалтын шаардлагыг хангагч	Сургалтын төлбөрийн 30%	Элссэн улирал
		Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK) 3-р түвшин авсан	Сургалтын төлбөрийн 40%	Элссэн улирал
		Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK) 4-р түвшин авсан	Сургалтын төлбөрийн 50%	Элссэн улирал
		Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (TOPIK) 5-р түвшин буюу түүнээс дээш авсан	Сургалтын төлбөрийн 80%	Элссэн улирал
		Хамтран ажиллах гэрээтэй их сургууль болон байгууллага	Сургалтын төлбөрийн 50%	Элссэн улирал (Элсэлтийн хураамж)
		Сургуулийн захирлын санал болгосон албан бичиг авсан тохиолдолд (сургалтын явцад жил тутамд 10 хүртэл хүн сонгон шалгаруулна)	Сургалтын төлбөрийн 100%	1-2 семестр суралцах явцад чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг олгохгүй
		Хамтран ажилладаг их, дээд сургуульд элсэлт (эхний хагас жил, хоёр дахь хагас жил) 6Үрд 15-с дээш оюутан бүртгэгдсэн тохиолдолд, хамтран ажилладаг их, дээд сургуулийн захирлын санал болгосон зөвлөмжийн захидал авсан хүн (15 оюутан тутамд 1 хүн)	Сургалтын төлбөрийн 100%	
	Гадаад оюутны богино хугацааны хөтөлбөрийн тэтгэлэг (1 жилийн хөтөлбөр)	1 жилийн богино хугацаат хөтөлбөрт элсэгч	Сургалтын төлбөрийн 30%	Элсэлтийн тэтгэлэг (Элсэлтийн хураамж)
Суралцагч оюутан (2~4 улирал)	Гадаад оюутны тэтгэлэг	Сүүлийн семестрийн дүнгийн дундаж 2.0-аас дээш 3.0-с багаар хамгаалсан	Сургалтын төлбөрийн 30%	
		Сүүлийн семестрийн дүнгийн дундаж 3.0-аас дээш 4.5-с доошгүй хамгаалсан	Сургалтын төлбөрийн 40%	
	Гадаад оюутны богино хугацааны хөтөлбөрийн тэтгэлэг (1 жилийн хөтөлбөр)	1 жилийн богино хугацааны хөтөлбөрт элсэгч		
		Сүүлийн семестрийн дүнгийн дундаж 2.0-аас дээш 3.0-с багаар хамгаалсан	Сургалтын төлбөрийн 20%	
		Сүүлийн семестрийн дүнгийн дундаж 3.0-аас дээш 4.5-с доошгүй хамгаалсан	Сургалтын төлбөрийн 30%	

※ Дэлгэрэнгүй мэдээллийг「Дээд сургуулийн тэтгэлгийн журам」-аас харна уу

2 Бусад зүйлс

- Тэтгэлэгт нэр дэвшигчийг их сургуулийн төгсөлтийн дараах сургуулийн тэтгэлгийн зөвлөл хянан Үзэж, эцсийн шийдвэрийг гаргана
- Суралцагч оюутан: F оноо авсан тохиолдолд тэтгэлгийн журамд Үндэслэн тэтгэлэгт нэр дэвших эрхгүй болно

7

Сургалтын төлбөр төлөх заавар

Банк ажиллах цагаар
(16:00өмнө)**1** Дотоодод амьдарч буй гадаад оюутан: Kookmin банкны виртуал данс руу хийх**2** Гадаадад амьдарч буй гадаад оюутан: Солонгосын банк ажиллах цагаар (16:00өмнө)
виртуал данс руу хийх

- KB Kookmin банкны англи нэр : KB KOOKMIN BANK
- KB Kookmin банкны англи хаяг : 26, Gukjegeumyung-ro 8-gil, Yeongdeungpo-gu, Seoul, Korea
- KB Kookmin Bank SWIFT (BIC) код : CZNBKRSE
- * Хэрэв 11 тэмдэгт шаардлагатай бол төгсгөлд нь XXX нэмнэ ҮҮ
- Тусдаа банкны дугаар байхгүй (ABA NO, ROUTING NO)
- Данс эзэмшигч : SHINHAN UNIVERSITY

※ Гадаадаас шилжүүлэг хийх Үед шимтгэл ногддог тул шимтгэлийг заавал шалгаж Үзнэ ҮҮ.

(Төлбөрийн дүнгийн алдаанаас Үүдэн төлбөр бүртгэгдээгүй тохиолдолд Үүсэх хариуцлага нь оюутанд өөрт нь хамаарна.)

3 Буцаан олголтын журам

Нэгж: Вон			
Хүсэлт гаргах хугацаа	Буцаан олгох мөнгөн дүн	БҮрдүүлэх бичиг баримт	БҮрдүүлэх газар
Улирал эхлэхээс өмнө	Сургалтын төлбөр/ Элсэлтийн төлбөр	Элсэлтээс татгалзах өргөдөл (Сургуулийн веб сайт - маягт оруулсан цэс - маягт татах) ※ Заавал өөрийн гарын Үсэг	Сургалтын алба
Улирал эхэлсний дараа	Бүртгэлтэй оюутны хувьд ※ Элсэлтийн хураамж буцаан олгогдохгүй	• Өөрийн (эсвэл төлөөлөгчийн) банкны дансны хуулбар • (Хэрэв төлөөлөгчөөр дамжуулан буцаан олголт хүсэж байгаа бол) Итгэмжлэл болон иргэний Үнэмлэхийн хуулбар	

※ Лавлах утас : ☎ 031)870-3403, 3398

8

Виза (VISA)-тай холбоотой мэдээлэл

1 Гадаад оюутны виз (D-2) хҮсэлт гаргах процедур**2 Гадаад оюутны виз (D-2) хҮсэлт гаргах ба олгох**

- [Дотоодод оршин суугаа гадаад оюутан](#)

- Дотоодод оршин суугчдын дунд ажил хайх виз (D-10) эсвэл хэлний бэлтгэлийн виз (D-4) эзэмшигч нь заавал оршин суух эрхийн өөрчлөлтийн зөвшөөрөл хҮсэж, хичээл эхлэхээс өмнө оюутны виз(D-2) болгон өөрчлөх ёстой.

※ Оюутны виз (D-2) эзэмшигч нь мөн хичээл эхлэхээс өмнө заавал сургалтын хҮсэлт гаргах шаардлагатай.

- Шаардлагатай бичиг баримт: Шинхан их сургуулийн албан ёсны вэбсайтын – Immigration / Visa самбар хэсгээс шалгана уу

- [Гадаадад оршин суугаа гадаад оюутан: Өөрийн улсын нутаг дахь БНСУ-ын Элчин сайдын яам эсвэл Консулын газарт визийн хҮсэлт гаргах](#)

- Шаардагдах бичиг баримт

① Стандарт элсэлтийн батламж (Шинхан их сургуулиас олгосон)

② Гадаад паспорт

③ Визийн хҮсэлт гаргах өргөдлийн маягт (Элчин сайдын яам эсвэл Консулын газарт байршуулсан)

④ Шинхан их сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээ (Стандарт элсэлтийн батламжтай цуг оюутанд илгээсэн)

⑤ СҮрьеэгийн оношилгоо

※ Гадаад дахь Элчин сайдын яамнаас хамааран нэмэлт бичиг баримт шаардлагатай байж болно

3 Гадаад иргэний бүртгэл

• Визийн олголтоос хойш 90 өдрийн дотор хҮсэлт гаргах ёстой (оршин суух эрхийн өөрчлөлт зөвшөөрөл авсан тохиолдолд даруй)

- Шаардагдах бичиг баримт: Шинхан их сургуулийн албан ёсны вэбсайтын – Immigration / Visa самбар хэсгээс шалгана уу

9

Бусад зҮйлс

1 Хичээл болон сургалтын хугацаа

- Хичээл : Ажлын өдөр (өдөр, орой), амралтын өдөр, зайны хичээл гэх мэт
- Сургалтын хугацаа : Магистрын хөтөлбөр : 2 жилээс дээш / докторын хөтөлбөр : 2 жилээс дээш
- Хичээлийн талаарх мэдээлэл, зөвлөгөө хҮсэх : ☎ 031)870-3393, 3404

2 Элсэлтийн талаарх дэлгэрэнгүй асуулт, мэдээлэл авах

- Ажлын цаг : Даваа ~ Баасан / 09:00 ~ 18:00 (Бямба, Ням гариг болон баярын өдрүүд: Амралтын өдөр)
- Лавлах утас : ☎ 031)870-3403, 3398(хятад), 3391(монгол) / FAX : (031)870-3409
- Баримт бичиг хҮлээн авах газар
 - Ыижонбү Их сургуулийн Үндсэн кампус (шуудан 11644) Гёнгидо аймгийн Ыижонбү хот, Хоам зам 95 (Ховон дүүрэг) Шинхан их сургуулийн Сион барилга, 4-р давхар, Сургалтын алба(4060тоот)
- Сургуулийн вэбсайт: <http://gs.shinhan.ac.kr>

3 Ирэх замын тайлбар

	
1) Ыижонбү кампус Метро 1-р шугам, Манвольса буудал (Шинхан их сургуулийн буудал)-д бууж, (1 минутын явган алхам) • (шуудан 11644) Гёнгидо аймгийн Ыижонбү хот, Хоам зам 95 (Ховон дүүрэг) Шинхан их сургуулийн Сион барилга, 4-р давхар, Сургалтын алба	1) Донгдучүн кампус Метро 1-р шугам, Донгчучүн ЖҮнган буудал (Шинхан их сургуулийн буудал)-д бууж, богино зогсолттой автобусаар 10 минутын зайтай • (шуудан 480-701) Гёнгидо аймгийн Донгчучүн хот, Болмадуро 40-р гудамж 30, Гол барилгын 1-р давхар, Сургалтын алба(1150тоот)
#11644, Graduate School Academic Affairs Team, 4F Zion Building, Shinhan University, 95, Hoam-ro, Uijeongbu-si, Gyeonggi-do, Republic of Korea	

10

Маягт

1. 개인정보활용 동의서/ Хувийн мэдээллийг ашиглах тухай зөвшөөрөл
2. 학력조회 확인서/ Боловсролын мэдээлэл шалгах баталгаа
3. 학업계획서/ Сургалтын төлөвлөгөө
4. 유학경비 부담서약서(Affidavit of Support)/ Гадаадад суралцах зардлыг хариуцах баталгааны бичиг

개인정보 수집 이용에 대한 동의서

본인은 신한대학교 일반대학원 및 폴리마데스대학원 입학지원서를 제출함에 있어 입학전형담당 기관이 본인에 대한 학력조회를 실시할 필요가 있다는 제반사항을 이해하고 있으며, 이를 위해 「개인정보 보호법」 등에 의해 보호되고 있는 본인에 관한 각종 정보자료를 ‘동법 제23조 단서 및 제15조, 고등교육법 시행령 제73조’에 따라 입학전형 담당기관이 수집 및 이용하는 데 동의합니다. 또한 본인이 서명날인한 동의서의 복사본은 학력조회에 필요한 다양한 자료 수집 및 이용의 편의를 위해서 원본과 동일하게 유효하다는 것을 인정합니다. 등록 시 학적서류로 향후 입학 후에도 학적 관리를 위한 정보 수집에 동의함

학력조회 및 학적관리를 위해 수집 및 이용되는 정보자료의 범위

☐ 개인정보의 수집 · 이용목적:입학전형, 학적부 기초자료, 학력 및 경력조회, 지원자 통계

☐ 수집하려는 개인정보의 항목

- 지원자 정보 : 국적, 성명, 주민등록번호, 주소, 전화번호, 직업, 병역사항, 이메일

- 학교 정보 : 출신학교명, 입학/졸업(예정)년도, 성적정보, 전형사항

☐ 개인정보의 보유기간은 이용목적에 따라 준 영구 보존이 됩니다.

☐ 개인정보의 보유기간 경과, 처리목적 달성 등 개인정보가 불필요하게 될 때에는 해당 개인 정보를 파기합니다.

☐ 입학 후 학력 · 경력조회 결과 입학지원서 및 제출서류에 기재된 내용이 사실과 다르거나, 지원자격에 미달(학력미인정, 성적미달 및 자격증, 면허증 미취득 등)되는 경우에는 입학허가 취소됩니다.

수탁업체	위탁업무내용/제공받는 자의 개인정보 이용목적	제공하는 개인정보 항목	제공받는 자의 보유 · 이용기간	기타
한국대학교육협의회	대학알리미에 진학 정보 제공	이름, 수험번호, 주민등록번호, 모집단위명, 합격여부, 등록여부, 장학금 수혜여부	처리목적 달성시까지	교육관련기관의 정보 공개에 관한 특례법
등록금 수납은행	실시간 등록금납입 문자발송	이름, 전화번호	해당등록기간	

개인정보의 제3자 제공에 동의하십니까?

☐ 동의함 / ☐ 동의하지 않음

※ 개인정보의 제3자 제공을 거부할 권리가 있으며, 이를 거부할 경우 대학원 입학원서를 접수할 수 없습니다.

☐ 지원자 본인 인적사항

- 주 소 :

■ 생년월일 :

■ 자택전화 :

■ 휴대전화 :

■ E-mail :

■ 국 적 :

■ 직 장 :

■ 직 위 :

■ 직장전화 :

■ 연락가능팩스 :

위 내용을 확인하였으며, 수험생 본인이 직접(동의함/ 동의하지 않음) 작성하였음을 확인합니다.

년 월 일

지원자 확인 : (서명)

신한대학교 대학원 귀하

학력조회 확인서
(Release of Information Form)

외국대학에서 수학한 지원자는 필수로 제출해야 함
(This form is mandatory for applicants who graduated from college or university in foreign countries)

지원자 정보(Applicant Information)	
성명(한글/영문) (Name of Applicant)	(Korean/English)
수험번호 (Applicant's Slate Number)	
지원학과/세부전공 (Department/Specific Major)	

출신대학 학력조회 동의(Letter of Agreement)	
I have applied to Graduate School of Shinhan University in Uijeongbu, Korea. In this regard, I would like to request your full assistance to Shinhan University when they contact you regarding verification of enrollment and transcripts.	
년 월 일 (Year/MM/DD)	
지원자: _____	(확인)
Applicant	Signature

출신학교 정보(Academic Information)	
학교명 (Name of Institution Graduated)	
학교주소 (Address of Institution Graduated)	
학위종류 (Name of Degree)	☐ 학부(Bachelor's Degree) ☐ 석사(Master's Degree) ☐ 박사(Doctor's Degree)
이수전공(Major)	
졸업(예정)일자 Date of (Expected) Graduation	
재학기간 및 등록학기 (Period of Attendance)	재학기간: 년 월 ~ 년 월, 총 () 학기 이수 (Year/MM) ~ (Year/MM), Total () Semesters Completed
홈페이지 주소 (Website of Institution Graduated)	

학력조회 요청 학교 정보 (Institution Information to Request Release Of Academic Information)	
학력조회 담당부서 (Office of Academic Record)	
학력조회 담당자 성명 (Name of Staff)	
담당자 연락처/팩스번호 (Phone/Fax No. of Staff in Charge)	(ex : 82-2-300-0000)
담당자 E-mail (E-mail of Staff)	

년 월 일 (Year/MM/DD)
지원자: _____ (확인)
Applicant Signature

학 업 계 획 서

영역별 500자 이상

지원과정	석사학위과정 () / 박사학위과정()
성 명 :	지원 전공 :
1. 진학 동기 및 목표	
2. 학부(석사)과정에서 관심 가졌던 활동 및 내용	
3. 진학 후 관심 연구 분야, 방향 및 내용(구체적으로 작성)	
4. 졸업 후 희망	

※ 위 양식의 공간이 부족한 경우 수정하여 작성하세요.

유학경비 부담서약서(Affidavit of Support)

은행잔고증명서의 명의를 본인이 아닌 경우에만 작성합니다.

지원자 성명 (Applicant's name)		생년월일 (Date of birth)	
수험번호 (Application number)		모집단위 (Major)	
학위과정 (Degree course)			

지원자의 유학경비를 부담할 개인이나 기관명을 쓰시오.

(Indicate the person, including yourself or organization that will be responsible for your tuition fee and living expenses.)

부담자 성명(기관명)(Name) :
관계(Relationship) :
직업(개인인 경우)(Occupation) :
주소(Address) :
전화번호(Phone Number) :

* 본인은 상기 지원자의 유학기간 중 일체의 경비부담을 보증합니다.

(I certify that I will be responsible for the above-named applicant's tuition fees and living expenses for the duration of the academic program.)

성명 _____ 서명 _____ 연월일 _____
(Name) (Signature) (Date)

신한대학교 대학원장 귀하